Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 731742,6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14634,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1077819,9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21556,3 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1404531,0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 62184,5 мянган төгрөгөөр буюу 4,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 253,511.0 | 280,750.5 | 27,239.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 2,494.9 | 2,494.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 253,511.0 | 278,255.6 | 24,744.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,088,835.4 | 1,123,780.4 | 34,945.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,372,819.7 | 2,459,696.7 | 86,876.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,283,984.3) | (1,335,916.3) | (51,931.9) |
| **Нийт хөрөнгө** | 1,342,346.4 | 1,404,531.0 | 62,184.6 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,342,346.4 | 1,404,531.0 | 62,184.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,342,346.4 | 1,404,531.0 | 62,184.6 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл 2494,9 мянган төгрөг болж өссөн нь Тайлант онд "Шинос мюзикл"-ын тасалбарын үнийг зарим иргэн, ААНБ-аас аваагүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 278255,6 мянган төгрөг болж 24744,6 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамж материалын дансны шинээр хийсэн урлагийн хувцсыг орлого авч үлдэгдэлтэй байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2459696,6 мянган төгрөг болж 86876,9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр төгрөгийн тоног төхөөрөмж 5000,0 мянга, тавилга эд хогшил 5965,2 мянга, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар ирсэн UAZ- 220695 маркийн 09-24 БНА улсын дугаартай 33600,0 мянган төгрөгийн автомашин, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 54311,6 мянган төгрөгийн өргөтгөлийг сайжруулалтаар хүлээн авсантай холбоотой байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10965,2 мянга, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 33600,0 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 54311,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данснаас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.03.04 ний өдрийн 20 тоот тогтоолоор акталсан 12000,0 мянган төгрөгийн үнэтэй "Toyota chaser" суудлын автомашиныг дуудлага худалдааны доод үнийг 1280,0 мянган төгрөгөөр тогтоож, дуудлага худалдаагаар 1580,0 мянган төгрөгөөр зарагдаж орлогын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1404530,9 мянган төгрөг болж 62184,5 мянган төгрөгөөр өссөн тайлант үеийн үр дүн 62184,5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1140004,5 мянган төгрөг болж, өмнөх оноос 177780,6 мянган төгрөгөөр буюу 18,4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 20261,6 мянган төгрөгөөр өссөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нэмэгдсэн, тусламж санхүүжилтийн орлого 157518,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 152561,1 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд орон сумын хөнгөлөлт 5000,0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 25993,8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 1077819,9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 132656,5 мянган төгрөгөөр буюу 14,0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-156704,4 мянга, халаалтын зардал 13860,0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 938821,2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 938821,2 мянган төгрөгөөр тооцон, ажиллагсдыг 60 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 115234,7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1054055,9 мянган төгрөгөөр, ажиллагсдыг 60 орон тоогоор баталсан байна Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 127535,9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж уран бүтээлийн зардлыг 13973,9 мянган төгрөгөөр буурсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1021099,0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1021099,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 1021099,0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1016649,0 мянган төгрөгийг зарцуулж 4449,9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1016649,0 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 3393,7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 504,4 мянга, хангамж бараа материалын зардлыг 96,3 мянга, томилолтын зардал 521,2 мянга, төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71702 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 4449,9 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй тайлан

*Хүснэгт -2* *төгрөгөөр*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Хөтөлбөр-71702 Соёл урлаг | 1,021,099.00 | 1,016,649.10 | 4,449.9 | 99.6 |
| Зориулалт- 80101 Үндсэн үйл ажилагааны зардал | 984,630.90 | 980,181.00 | 4,449.9 | 99.5 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 984,630.9 | 980,181.0 | 4,449.9 | 99.5 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 984,630.9 | 980,181.0 | 4,449.9 | 99.5 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 667,364.0 | 663,970.2 | 3,393.8 | 99.5 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 90,364.1 | 90,364.1 | 0.0 | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 203,263.6 | 202,759.1 | 504.5 | 99.8 |
| Хангамж, бараа материалын зардал | 10,687.8 | 10,685.5 | 2.3 | 100.0 |
| Норматив зардал | 3,340.7 | 3,340.7 | 0.0 | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 5,300.0 | 5,284.5 | 15.5 | 99.7 |
| Томилолт, зочны зардал | 2,693.2 | 2,172.0 | 521.2 | 80.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,617.5 | 1,604.9 | 12.6 | 99.2 |
| Хөтөлбөр-71702 Соёл урлаг | 30,599.7 | 30,599.7 | 0.0 | 100.0 |
| Зориулалт- 80214 Уран бүтээл | 30,599.7 | 30,599.7 | 0.0 | 100.0 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 30,599.7 | 30,599.7 | 0.0 | 100.0 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 30,599.7 | 30,599.7 | 0.0 | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 30,599.7 | 30,599.7 | 0.0 | **100.0** |
| **Хөтөлбөр-71702 Соёл урлаг** | 5,868.4 | 5,868.4 | 0.0 | **100.0** |
| **Зориулалт- 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал** | 5,868.4 | 5,868.4 | 0.0 | **100.0** |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,868.4** | **5,868.4** | **0.0** | **100.0** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **5,868.4** | **5,868.4** | **0.0** | **100.0** |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн | 5,868.4 | 5,868.4 | 0.0 | **100.0** |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 24250,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулж үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан 915,5 мянган төгрөгийг төвлөрүүлж зориулалтын дагуу 926,4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт:

| Хүснэгт-3 | | /төгрөгөөр/ |
|---|---|---|
| Гүйлгээний утга | Орлого | Зарлага |
| Орон сууцны хөнгөлөлт | 5,000,000.0 | - |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 23,498,893.0 | |
| Орон сууцны хөнгөлөлт | - | 5,000,000.0 |
| Уран бүтээлийн зардалд | - | 3,083,000.0 |
| Албан хаагчдын шагнал урамшуулал, тэтгэмж | - | 9,239,100.0 |
| Албан хаагчдыг нийгмийн асуудал шийвдэрлэхэд | - | 10,003,048.0 |
| Үйл ажиллагааны зардалд | - | 1,173,745.0 |
| Дүн | 28,498,893.0 | 28,498,893.0 |

*Эх сурвалж: Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 129 мэдээллийг хугацаанд нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ 53 мэдээллийг хугацаа хоцроож, санхүүгийн тайлан хагас жил, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй байна.

*Хүснэгт-4*

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь байршуулсан | Хугацаа болоогүй | Хугацаа хоцроож байршуулсан | Мэдээллийг хугацаандаа байршуулаагүй | Үнээс Хугацаа хоцроож байршуулсан | | | | | | | | | | | | | Байршуулаагүй | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төлөрүүлэх төлбөр, хураамж, | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /мян.төг/ | | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил | Санхүүгийн тайлан | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан |
| | | | | | | | | Тоо | Тоо | Тоо | Тоо | Тоо | Тоо | Тоо | | | Тоо | Орлого | Зарлага | Тоо | Тоо | Тоо |
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 2 | | 1 | | | | | | | | | | | | | | | 1 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | 1 | 1 | | | | | | | | | | | | | | 1 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | | 1 | | 1 | | | | | | | | | | | | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 27 | | 6 | | 3 | | 3 | | | | | | | | | | | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 86 | | 46 | | | 7 | | 4 | 4 | 9 | 3 | 5 | 4 | 5 | 410,042 | 64,295 | 5 | | |
| | Нийт | 27 | 151 | 129 | 2 | 53 | 2 | 4 | 7 | 3 | 4 | 4 | 9 | 3 | | | 5 | 410,042 | 64,295 | 5 | 1 | 1 |

*Эх сурвалжийг: Тус байгууллагын шилэн дансны цахим сайтаас*

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1375,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг 2020.04.21 өдрийн №47 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22605,8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7149,6 мянган төгрөгийн алдааг залруулж, 2061,5 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1500,0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 11894,7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13 нэр төрлийн 24689,7 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлыг байгуулаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Элэгдэл байгуулаагүй 13 хөрөнгийн элэгдлийг байгуулж тайлант үеийн элэгдлийн зардалд 7134,8 мянган төгрөгийн элэгдлийг тооцуулж залруулга хийв.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 15456,2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2061,5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1500,0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ Үүнд:



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1. Байгууллагын даргын 2020.01.08 Б/05 тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан 2 албан хаагчид 429,6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, 12 дугаар сард хамтын сангийн мөнгө 300,0 төгрөгийг 2 удаа шилжүүлж, авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал...14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага бүртгэнэ, Засгийн газрын 2019.01.09 ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвөөс илүү зарцуулсан 729,6 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Үндсэн үйл ажиллагааны орлогоос тушаал шийдвэргүй 1331.9 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зориулалт бусаар зарцуулж. Сангийн сайдын 2019.03.27 ний өдрийн 74 тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт, орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-г зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан 1331,9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллагад 7 дугаар сард гэрээт ажилтнаар ажилласан Л.Пүрэвсамбуугийн ажилласан хугацааны цалинг 1500,0 төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд мэдээлээгүй. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалт зөрчсөн байна.
<u>Шийдвэрлэсэн нь</u>: Дутуу мэдээлсэн 1500,0 мянган төгрөгийг НДХ-т нөхөн мэдээлэх албан шаардлага өгөв.

4. Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих мэдээллээс мэдээллээс санхүүгийн тайлан хагас жил, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 410042,0 мянган, зарлагын 64295,0 мянган төгрөгийн 53 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансанд мэдээлээгүй мэдээллийг нөхөж мэдээлэх албан шаардлага өгөв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 11894,7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**1. Балансын данстай холбоотой асуудал:**

*1.1 Илрүүлэлт:* Тайлант онд иргэн, аж ахуй нэгж байгууллагаас "Шинос" мюзикл жүжгийн тасалбарын 2494,9 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*1.2 Эрсдэл:* Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

*Өгсөн зөвлөмж:* Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого болох үзвэрийн тасалбарын орлого 2494,9 мянган төгрөгийг иргэн, ААНБ-аас 2020.04.15 ний дотор авлагыг бүрэн барагдуулан цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

*1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

***2. Орлогын данстай холбоотой асуудал:***

*2.1 Илрүүлэлт:* Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 23498.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2020.12.03 ний өдрийн А/785 тоот захирамжаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах шийдвэр гарсны дагуу хамт олны хурлаар хэлэлцүүлж байгууллагын даргын тушаалаар 12767,1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 9399,8 мянган төгрөгийг захирамж гараагүй байхад зарцуулсан нь Сангийн сайдын 2019.03.27 ний өдрийн 74 тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт, орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-г зөрчсөн байна.

*2.2 Эрсдэл:* Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг зориулалт бусаар зарцуулах.

*Өгсөн зөвлөмж:* Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үнэн зөв төлөвлөж батлуулж, Сангийн сайдын 2019.03.27 ний өдрийн 74 тушаалын мөрдөн ажиллаж төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах хүсэлтийг аймгийн Засаг даргад тавьж, эрх бүхий байгууллагын шийдвэр, захирамж гараагүй байхад зарцуулдаг явдлыг таслан зогсоох.

2.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл***

*3.1 Илрүүлэлт:* Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 2005 онд боловсруулсан НБББББ нь шаардлага хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэн заалтад нийцэхгүй байна.

*3.2 Эрсдэл:* Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

2.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР Г.ГАНЧИМЭГ
Огноо: 2021.02.23

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.23

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.23

6417143544
БЮА0067 9007423



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/49/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос тушаал шийдвэргүй 1331.9 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зориулалт бусаар зарцуулж. Сангийн сайдын 2019.03.27 ний өдрийн 74 тушаалыг зөрчсөн. | 1331.9 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 2 | Байгууллагын даргын 2020.01.08 Б/05 тушаалаар сахилгын шийттэл ноогдуулсан 2 албан хаагчид 429,6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, 12 дугаар сард хамтын сангийн мөнгө 300,0 төгрөгийг 2 удаа шилжүүлж, авлагаар тусгаагүй | 729.6 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 3 | Тус байгууллагад 7 дугаар сард гэрээт ажилтнаар ажилласан Л.Пүрэвсамбуугийн цалин 1500,0 төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд мэдээлээгүй. | 1500.0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 4 | Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу мэдээлэх мэдээллээс Санхүүгийн тайлан хагас жил, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, 53 мэдээллийг хугацаа хугацаа хоцроож байршуулсан, Үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 410042,0 мянга, зарлагын 64295,0 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. | 0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 5 | Тайлан онд иргэн аж ахуй нэгж байгууллагаас "Шинос" мюзикл жүжгийн тасалбарын үнэ 2494.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй. | 2494.9 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 6 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 2005 онд боловсруулсан НБББББ нь шаардлага хангахгүй байна. | 0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 7 | Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 23498.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2020.12.03 ний өдрийн А/785 тоот захирамжаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах шийдвэр гарсны дагуу хамт олны хурлаар хэлэлцүүлж байгууллагын даргын тушаалаар 12767,1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 9399,8 мянган төгрөгийг захирамж гараагүй байхад зарцуулсан | 9399.8 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| 8 | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13 нэр төрлийн 24689,7 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлыг байгуулаагүй байна. | 7149.6 | Санхүүгийн тайланд залруулга хийх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Б.Пүрэвдагва, Ч.Энхжаргал |
| ДҮН | | 22605.8 | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ